



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/18

Рашаант сум

**Орон тооны бус зөвлөлийг татан
буулгах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, "Тушаал хүчингүй болгох тухай" Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/20 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 1/318 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу Даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох Засаг даргын дэргэдэх орон тооны бус байнгын зөвлөлийг татан буулгасугай.

2.Засаг даргын дэргэдэх орон тооны бус байнгын зөвлөлийн шийдвэр, хурлын тэмдэглэл, бусад холбогдох баримт материалыг аймгийн Нийгмийн даатгалын газарт хүргүүлэхийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга, нийгмийн даатгалын байцаагч (Н.Өлзийжаргал)-д даалгасугай.

3."Засаг даргын дэргэдэх орон тооны бус байнгын зөвлөл байгуулах тухай" сумын Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/124 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ